

МАТЕРИАЛИСТ ҮЗЛИЙН ТАЛААРХ БУДДЫН ФИЛОСОФИЙН ТАЙЛБАР

Доржав Мархаев - МУИС. НШУС, Шашин судлалын тэнхим, докторант

Түлхүүр үг: Дүрс, матер, өвөрмөц өгүүлэгч, судартан, төв үзэл, сэтгэл төдийтөн, сав ертөнц, шүтэн барилдлага, ахуй, оршихуй

Товч утга: Бурханы сургаал ёсоор үнэн (бодьтой) гэж бид бодож төсөөлж байгаа зүйлсээ мөнх, тогтмол хэмээн сэтгэдэг (энэ бол нэг талын Туйлчлах үзэл). Тухайн юм үзэгдэл бидний мэдрэхүй хүртэхүйд байхгүй бол түүнийг "бүрмөсөн байхгүй" хэмээн сэтгэдэг (нөгөө талын Үгүйсгэх үзэл). Энэ хоёр хязгаар үзэл нь материйн чанар ба материйн шинжийн нөлөөгөөр үүсдэг. Материализмын найман хязгаар үзлийг үүсгэнэ: Буддын сургаалд дүрс тэргүүтэй юм үзэгдлийг шалтгааны эрхээр үүссэн гэж үзэх тул анхдагч субстанцийн асуудлыг тойрон гардаг байна. Ертөнцийг хүмүүс өөр өөрсдийн сэтгэлийн төлөв байдалд нийцүүлэн ухаардаг ажээ.

Ертөнцийг үзэх материалист үзэл нь идеалист үзлийн эсрэг үзэл мөн. Материализм нь ертөнцийн объектив бодит байдлыг хүлээн зөвшөөрч үүсдэг ба үүгээрээ ч объектив нэгдлийг тайлбарлана. Идеализм нь ертөнцийн нэгдлийг оюун санааны үндсээр тайлбарлана. Ертөнцийн нэгдлийг сэтгэлгээнээс, сэрлээс, "туйлын оюун санаанаас" гарган авдаг. Ертөнцийн талаар санаж сэтгэх нь нэг байдаг учраас ертөнц нэг хэмээх нотолгоог тэд үндэс болгоно. Материалистууд санаа ухамсрын элементүүд нь материаллаг эх загвартаа үнэхээр нэгдэж байвал л тэдгээрийг сэтгэлгээгээрээ мөн нэгтгэж болно хэмээн нотолдогоороо идеализмыг шүүмжилдэг. Ертөнцийн нэгдэл нь түүний оршин ахуйд байгаа бус аа.

Ертөнц нэгдмэл байхаасаа өмнө оршин байх хэрэгтэй гэсэн материалистуудын логик байгууламж зөв байна. Ямарваа юм нэгдмэл, эсвэл ялгаатай гэдгээ харуулахын өмнө эхлээд өөрөө оршин байх хэрэгтэй учраас ингэж тайлбарлах нь зөв өө. Юмс үзэгдэл нь ерөнхий чанартай аваас харилцан нэгдмэл байх боломжтой. Эндээс үүдэн, юмс үзэгдэл нэг харилцаанд нэгдмэл байж болох боловч чанарын өөр харилцаанд ялгаатай байж бас болно.

Энэхүү нэгдмэл ба ялгаатай талыг Гегелийн авсан "Алим, лийр ялгаатай боловч үр жимс гэдгээрээ ерөнхий (нэгдмэл)" гэсэн жишээгээр тайлбарлаж болно. Иймэрхүү жишээг бид буддын логикоос харж болно. Тухайлбал, буддын логикт ерөнхийгөөс нэгжид хандах харьцааг «ཐུན་མཁན» буй, харин «ཐུན» буй бус учраас «ཐུན་མཁན» болой гэсэн жишээгээр тайлбарладаг. Энэ тохиолдолд бид үгээр хөөцөлдөх шаардлагагүй учраас Гегелийн хийсвэрлэлээс зайлсхийж байна⁵¹.

Одоо Бурханы сургаалд Материализмын найман хязгаар үзлийг хэрхэн авч үздэгийг сонирхоё. Үнэн (бодьтой) гэж бид бодож төсөөлж байгаа зүйлсээ мөнх, тогтмол хэмээн сэтгэдэг (энэ бол нэг талын Туйлчлах үзэл). Тухайн юм үзэгдэл бидний мэдрэхүй хүртэхүйд байхгүй бол түүнийг "бүрмөсөн байхгүй" хэмээн сэтгэдэг (нөгөө талын Үгүйсгэх үзэл). Энэ хоёр хязгаар үзэл нь материйн

⁵¹ К. Маркс и Ф. Энгельс. Святое семейство, соч. т.2 стр. 63 - 66

чанар ба материйн шинжийн нөлөөгөөр үүсдэг Материализмын найман хязгаар үзлийг үүсгэнэ. Үүнд:

1. Оршин ахуй буй бус хэмээх Бодгалийн Би-үгүйн үзэл «གང་ཟག་གི་བདག་པོ་» - энэ нь “Өөрийн орших ахуйн үүсэл” байхгүй, өөрөөр хэлбэл материйн үүсэл ч, устал ч байхгүй гэх үзэл юм «མི་རྒྱལ་».

2. Төгсгөл байхгүй хэмээх хорих үгүй үзэл «འགག་པ་མེད་».

3. Оршин ахуйн хязгаар байхгүй хэмээх үзэл «ཆད་པ་མེད་».

4. Няцаалт үгүйсгэл үгүй хэмээх “буй”-н үзэл «ཡོད་པ་».

5. Ирэхүй үгүй хэмээх үзэл «འོང་བ་མེད་པ་».

6. Одохуй үгүй хэмээх үзэл «འགྲོ་བ་མེད་པ་».

7. Нэгж «ཉི» ба олон «ལྔ» гэх нь үнэнхээр чанар үгүй гэх үзэл.

8. Авахуй үгүй, бэлгэ үгүй хэмээх үзэл «མཚན་མེད་». Одоо бурханы сургаалд ертөнцийн анхдагч эх үүсвэрийг хэрхэн тайлбарладгийг авч үзье. Шамбалын диваажингийн орныг аваад үзье л дээ. Дэлхийн газрын зургийг алдаатай дүрсэлсэн тал бий. Гэхдээ ертөнцийг төсөөлсөн төсөөлөл нь бүхэлдээ шинжлэх ухаанч байна. Маш нарийн тоосны тухай буюу атомын сургаалыг бүр эртний энэтхэгчүүд л боловсруулжээ.

Орчлон ертөнц нэгдмэл бодит чанартай, физикийн ч, сэтгэлийн ч үзэгдлүүд өөр хоорондоо уялдаа холбоотой гэдэгтэй байгалийн ухааны төлөөлөгчид улам бүр санал нэгдсээр байна. Бурханы сургаалтнууд үүнийг хоёр мянга таван зуун жилийн тэртээгээс айлдсан билээ. Ус, бид байнга хэрэглэдэг, бидний өдөр тутмын хэрэглээний ердийн усны жишээгээр аваад үзэхэд л маш сонирхолтой дүр зураг харагдана. Усны молекулын бүтэц янз бүрийн физик үйлчлэл үзүүлэх тутам өөрчлөгдөж байх боловч, харин химийн найрлага нь хэвээр хадгалагддаг гэдгийг туршлагаар баталсан байдаг. Орчин үеийн лабораторид хийсэн туршлагаар усны бүтцэд нэлээд том өөрчлөлт явагдахад тэр нь хүний сэтгэл хөдлөлд, үг ярианд, ухаан санаанд нь нөлөөлж байдгийг харуулсан байна. Одоогоор эрдэмтэд энэ тохиолдлыг тайлбарлаж чадаагүй байгаа юм.

Ганц л тайлбар бий: ус ба хүрээлэн буй орчин хоёр хоорондоо харилцан үйлчилдэг, шүтэн барилддаг. Сэтгэл хөдлөлийн тухайд гэвэл, усны чанар нь ашигтай, эсвэл сөрөг аль нэг тал руу өөрчлөгдөнө хэмээн бид хэлнэ. «འཕྲིལ་» зан үйл явуулах үест ус эмчлэх гэх мэт чанартай болдог. Хүний Биед байгаа ус төрсөн газрынх нь усны найрлагатай адил байдаг гэсэн эрдэмтдийн тодорхой дүгнэлт бий, иймээс хүн төрсөн газартаа биеийн энерги дулаанаа сайжруулах боломжтой, ус нь энерги дулааныг ой санамжиндаа хадгалдаг ба энергийг дамжуулан мэдээлэх чадвартай.

Ямар нэг зүйл хийх гэсэн оролдлого, хүний сүсэг бишрэл усанд хадгалагдах тул усаар хүнийг эмчилдэг. Эрдэмтдийн тогтоосноор, 10 грамм усаар 16 литр усны чанарыг өөрчилж болно. Энгийн жишээ авъя: төс хичнээн хатуу байлаа ч мөн чанар нь ус билээ. Нөхцөл нь бүрэлдэхэд ус мөс болж хувирна, дараа нь эргээд ус болно. Шүтэн барилдлага буюу харилцан

хамаарлын эхний түвшин нь шалтгаан нөхцлөөс гарах хамаарал болно. Бидний “Би” хэмээх ухамсар сэтгэл оршин ахуй байдлаараа устай адил.

Ус гэж юу вэ? Ус бол хүчилтөрөгч, устөрөгч хэмээх хоёр элементээс хамаарах үзэгдэл мөн. Ус нь хүчилтөрөгч, устөрөгч хоёроос хамаарах тул юунаас ч үл хамаарах субстанц үндэс түүнд алга, тэр үндэс нь хоосон. Юунаас ч үл хамаарах субстанц үндэс гэж юу вэ? Бид “ус” гэсэн үзэгдэлтэй харьцах үест тэр нь юунаас ч үл хамааран, субстанц байдлаар оршин байгаа мэтээр, тодорхой Биет юм мэтээр, цор ганцаараа байгаа мэтээр санагдаж объектив бодит зүйл хэмээн заан нэрлэдэг. Энэхүү “ус” хэмээх үзэгдлийг судлаад үзэхийн цагт юунаас ч үл хамааран тогтвортой орших ус хаа ч алга гэдгийг харна. Ус бол олон хүчин зүйлийн нэгдэл гэдгийг бид тогтоодог. Дээр дурдсан бүх жишээ баримтууд усны хоосон мөн чанарыг, тэрчлэн байгаль дахь бүтэцлэг юм үзэгдэл бүхэн бас ийм гэдгийг харуулж байна. иймээс бурхан шашинтнууд “үзэгдлүүдийн туйлын мөн чанар бол хоосон чанар” хэмээдэг юм. Хоосон чанар нь өөрийн оршин ахуйгаас гарна. Хоосон чанар бол бүх юм үзэгдлийн эцсийн мөн чанар. Бурхан шашинтнууд: “бүх үзэгдлүүд хоосны агаараас үүсч, хоосны агаарт замхрана” хэмээдэг. Энэ нь телевизорын дэлгэц лүгээ асаад унтардагтай адил.

Сурвалжид өгүүлэхдээ: «Дүрс хоосон болой. Хоосон нь дүрс болой. Дүрсээс өөр хоосон үгүй болой. Тэрчлэн хоосноос өөр дүрс үгүй болой». Дүрсийн цогцыг ухаан санаанд туссан тусгал гэж тодорхойлдоггүй, ерөөсөө ухааршгүй, судалж шинжилшгүй гэж үздэг байна. “Бэлгэ чанарын үндсийг” нарийвчлан задлан шинжлээд түүний өөрийн оршин ахуйг нь үнэмлэхүй (оршин ахуй)-н хүрээнд олж тогтоож чадахгүй. Иймээс тэр (дүрсийн цогц) бээр өөрийн буюу өөрийн мөн чанараараа хоосон (хэмээн өгүүлдэг). Жишээ нь, усанд туссан сарны тусгал, зэрэглээ, зүүд, илбэний морь, заан мэт нь зөвхөн ухаан санаан дахь дүрслэл төдийгүй үзэгдэл төдий зүйл болохоос жинхэнэ сар мэт бус болой. Бэлгэ чанарын үндсийг хэрхэн эрэн хайх аргыг доор өгүүлнэ. Объектын өөрийн мөн чанар үгүйг няцаах нь түүний оршин ахуйг няцааж байгаа хэрэг бус уу? Үгүй ээ, “хоосон” хэмээх нь өөрийн мөн чанараараа дүрс болон нөхцөлдөн илэрч буй. Жишээ нь, сарны тусгал нь сар бус, харин сар мэт үзэгдэх дүрс боловч (тусгалын нөхцөлт оршин ахуйд) зөрчилдөхгүй. Ийнхүү, сарны тусгал нь сар бус гэдэгтэй адил “дүрс” нь өөрийн орших “дүрс” бус аа. Үүнийг өөр жишээгээр хэрхэн нотлох вэ? Үүнийг мэдэх нь нэн чухал бөгөөд дэлгэрэнгүй тайлбар хэрэгтэй болно. Үүний тулд Зонхав богд, түүний шавь нарын Бичсэн аугаа сурвалжуудыг үзэж судлах хэрэгтэй. Дүрсийн тусгал нь (жинхэнэ) дүрс болж чадахгүй гэсэн жишээг авч дүрсийн (бүхий л) цогцын өөрийн оршин ахуй үгүй гэдгийг ойлгож болно. Дүрсийн тусгал, жишээ нь толинд туссан дүрс жинхэнэ уг зүйл бус гэдгийг ердийн ухамсар сэтгэлээр ухаарч чадна. Дүрсийн ийм тусгалыг ердийн ухаанаар хий үзэгдэл хэмээн нэрлэдэг. Дүрс нь өөрийн мөн чанараар орших үгүй боловч сансарын (ердийн) сэтгэлгээгээр ингэж

төсөөлөгддөггүй. Ийм хэлбэрийг жинхэнэ оршин байна гэж үзэх боловч төв үзлийн гүн ухаанаар (өөрийн оршихуй) буй бусыг ухаарч болно. Төв үзэлд үүнийг хий үзэгдэл гэж үзнэ. Жирийн хүмүүст хий үзэгдэл Биш, харин жинхэнэ бодит байдал гэж төсөөлөгддөг, өөрийн оршин буй мэт дүрс тэргүүтэй таван баригдахууныг мадагтай хэмээн ертөнцийн хий үзэгдлийн жишээгээр тайлбарладаг.

Вималакиртийн төв үзлийн тайлбар шастирт бидний бие махбодын онцлог шинжийг тайлбарласан буй. «Анд нөхөд минь ээ, энэ бие махбод нэгэн хэвийн бус аа, тогтвортой суурь үгүй ээ, найдвар үгүй ээ, сул дорой, богино настай, зовлонтой, арвин их өвчинтэй, хувирамтгай билээ. Иймээс анд нөхөд минь ээ, энэ бие махбод бол арвин их өвчний үүр учраас л ухаан билигт хүмүүн түүнд автагдах учиргүй болой. Анд нөхөд минь ээ, энэ бие махбод нь усан дээрхи хөөс лүгээ цавчилт цохилтыг тэсэхгүй ээ. Энэ бие махбод нь нисваанисын шунал тачъяалаас зүүд зэрэглээ мэт үүссэн болой. Энэ бие махбод нь гадилын модны хоосон иш лүгээ мөн чанаргүй болой. Энэ бие махбод нь тэрэг лүгээ булчин шөрмөсөнд баригдсан араг яс болой. Энэ бие махбод нь хий хоосон зүйл лүгээ худал хуурмагаас үүссэн болой. Энэ биемахбод нь зүүд зэрэглээ мэт бодит бус зүйлийг жинхэнэ хэмээн хардаг болой. Энэ биемахбод нь толинд буусан дүрс лүгээ өмнөх үйлийн тусгал болой.

Энэ бие махбод нь цуурай мэт шалтгаанаас хамаарна. Энэ бие махбод нь үүл манан мэт тогтворгүй санаа бодолтой, салган хийсвэрлэх чанартай болой. Энэ бие махбод нь аянга цахилгаан лугаа нэгэн агшинд л устаж үгүй болно. Энэ бие махбод нь эзэн үгүй мэт олон янзын шалтгаанаас үүснэ. Энэ бие махбод нь үйлчлэл үгүй шороо лугаа адил болой. Энэ бие махбод нь чанар үгүй ус лугаа адил болой. Энэ бие махбод нь амь үгүй гал лугаа адил болой. Энэ бие махбод нь хувь чанар үгүй хий лүгээ адил болой. Энэ бие махбод нь оршин ахуй үгүй орон зай лугаа адил болой. Энэ бие махбод нь үнэнхээрийн шинж үгүй дөрвөн махбодын орон болой. Энэ бие махбодод “Би” үгүй, минийх гэх юу ч үгүй, хоосон болой. Энэ бие махбод нь хагдарсан өвс ногоо, мод ургамал, атга шороо, бүрэлзсэн нүд мэт амьгүй, хөгшин болой. Энэ бие махбод нь салхи мэт сэрэхүй үгүй болой. Энэ бие махбод эцэстээ үхэж үгүй болно. Та бүхэн энэхүү бие махбодын талаар тунгааж, түүнд үл шунан, Түүнчлэн ирсэний биеийг зорин сүсэг төрүүлэх хэрэгтэй.

Анд нөхөд минь ээ, Түүнчлэн ирсэний бие – Номын бие нь билиг ухаанаар төрнө». Вималакирти айлдлынхаа эхэнд жирийн хүмүүс бид бүхний хувьд хамгийн ойр, хамгийн ойлгомжтой жишээг татсанд л түүний энэхүү сургаалын уран чадвар, ухаан билиг нь оршиж байгаа юм.

Мөн сэтгэл төдийтний сургаалтнууд «མིཤམ་ཅན་གྱི་ལྷན་པས།»-аас «དངེས།» хэмээх бүлэгтээ сонирхолтой жишээ татдаг.

шувууд хамгийн сайхан дуугаа дуулж, ертөнц маань амлалт аз жаргалаар дүүрэн байдаг. Харин гутарсан үед ертөнцийн өнгө урсан нүүж, зэс нь цухуйж, бүх юм буруу, утгагүй мэт болдог. Гутарсан болон дурласан хүн хоёр нэгэн ижил гудамжаар явах үед тар хоёрын алд дэлмээр ялгаатай ертөнцөөс гадна өөр нэгэн ертөнц оршиж байна уу? Тэр гудамж нэгэн зэрэг сайхан, муухай байна гэж үү? гудамжинд буй байшин, мод, цэцэрлэгүүд өөрөөсөө бүтэж оршихгүй хэмээн Бурхан багш тайлбарлажээ⁵³.

Ийнхүү ертөнцийг хүмүүс өөр өөрсдийн сэтгэлийн төлөв байдалд нийцүүлэн ухаардаг ажээ.

SUMMARY

Immortalization is one of two limited viewpoint caused by thinking that the Reality is the Eternality. Other limited viewpoint is thinking that unknown or unrevealed things are not exist. These two limited viewpoints are caused by personal qualities or characters. The Madhyamaka Philosophy is criticizing eight principles of materialist viewpoint. By the Buddhist philosophy all matters are appearing by causality. Therefore they doesn't recognize any first cause or substantial beginning of the Universe. The Universe is known by people as they understand it personally.

НОМ ЗҮЙ

1. Дармакирти / Tshad ma rnam grel gyi li'l dang po'i;grel pa.
2. Дармакирти. Gtan tshigs pa. Данжуур. Т. се. Энэ зохиолыг Д.Туччи в 1956 онд хэвлүүлсэн. /Serie orientale Rome. 1956.
3. Дигнага. Gtan tshigs kyi khor lo gtan la dbab pa
4. Винитадева. Gtan tshigs thigs-pai rgya cher 'grel pa. Данжуур. The-110
5. Винитадева. tan tshiga Rcod pa rigs pa. Данчжур. Tshe-III.
6. Нагаржуна. Дундад үзлийн ухааны чуулган. Эрхэлсэн Г.Лувсанцэрэн. УБ. 2002.
7. Богд Зонхав Лувсандагва "Мөрийн гурван эрхэм"
8. Далай лам Данзанжамц. Шүтэн барилдлагын магтаал сайн номлолын эрхин хэмээх оршвой. УБ 2006,
9. Далай лам Данзанжамц. Их бодь мөрийн зэргийн тайлбар. УБ. 2009.
10. Далай лам Данзанжамц. Буддын ертөнц.
11. Гэлэн лам Түвдэнжамц, Буддизм бидний амьдралын хэмнэлд. УБ. 2004.
12. Гона Лама Дагва Шедуб «Солнце, освещающее истинную природу сокровенного»
13. Жамьян Жамц гэвш, Зүрхэн судрын тайлбар
14. Робсон.К., "Бодит ертөнцийг судлахуй", УБ., 2006 он.
15. Васильев С.А. Философский анализ гипотезы лингвистической относительности. Киев. 1974.
16. Гантуяа.М., "Буддын философи судлалын зарим асуудал", УБ.,2004 он
17. Лувсанцэрэн.Г., "Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас", УБ., 2008 он.
18. К. Маркс и Ф. Энгельс. Святое семейство, соч. т.2
19. А.Терентьевы «Буддизм: Түүх ба соёл»
20. Щербатской Ф.И. Теория познания и логика по учению позднейших буддистов. Ч.2 Спб., 1909.
21. Большая Советская энциклопедия. М.1984. Время.

⁵³ Гэлэн лам Түвдэнжамц, Буддизм бидний амьдралын хэмнэлд. УБ. 2004. х.58-59